



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон
барилгуудад хийх аудит

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 он

АГУУЛГА

Аудитын нэр	1
Аудитын код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Аудитын хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	3
Эрсдэлийн үнэлгээ	4
Аудитын арга зүй	4
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	4
Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл	5
Аудит хийх бүрэлдэхүүн	5
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	5
Хавсралт 1. Эрсдэлийн үнэлгээ	
Хавсралт 2. Асуудлын шинжилгээ	
Хавсралт 3. Арга зүй	
Хавсралт 4. Аудитын хөтөлбөр	
Хавсралт 5. Аудитын үр өгөөжийн төлөвлөлт	
Хавсралт 6. Шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээний зардал, томилолтын тооцоо	
Судалгаа 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 оноос хэрэгжиж эхэлсэн боловч улсын комиссын акт гараагүй дуусаагүй барилгын жагсаалт	

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

БАТЛАВ.

Д.ХҮРӨЛБААТАР



АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудад аудит хийх

2. Аудитын код

ГАГ-2018-02-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн ажлыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй шалтгааныг тодорхойлж, барилга, байгууламжийн одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, аудитын дүн, дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй барилга, байгууламжийн орхигдсон үндэслэл, шалтгааныг тогтоосон эсэх,
- Дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжийг тодорхойлсон эсэх.

5. Аудитын хамрах хүрээ

Аудитад 2010 оноос хойш улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж, баригдаж эхэлсэн боловч санхүүжилт нь зогссон, барилга угсралтын ажил дуусаагүй, ашиглалтад ороогүй, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуулийн 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад тусгагдаагүй төсөл, арга хэмжээг хамруулна.

6. Үндсэн мэдээлэл

Монгол Улсын 2010-2016 оны төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан боловч санхүүжилт нь зогсож, барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, улсын комисст хүлээлгэн өгөөгүй 162.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 43 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр төсөл, арга хэмжээнд 2010-2016 онуудад 76.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй орхигдсон 43 барилгыг төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын багцаар ангилбал: БСШУСС-ын багцад 54.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 22,

БХБС-ийн багцад 35.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11, ХХААХҮС-ын багцад 10.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2, ЭМС-ын багцад 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2, ЗГХЭГ-ын даргын багцад 1.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2, ШЕЗ-ийн даргын багцад 52.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1, ХНХС-ын багцад 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1, ЗТХС-ын багцад 0.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1, БХС-ын багцад 0.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Дээрх төсөл арга хэмжээг хэрэгжилт эхэлсэн оноор нь авч үзвэл, 2010 оны 3, 2011 оны 6, 2012 оны 15, 2013 оны 10, 2014 оны 8, 2016 оны 1 төсөл, арга хэмжээ байна. Нийт дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн 76.7 хувь нь 2011-2013 онуудад баригдаж эхэлсэн байна.

7. Эрсдэлийн үнэлгээ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. *(Эрсдэлийн үнэлгээг хавсралт 1-ээс үзнэ үү.)*

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд, судлаачид, шинжээчидтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, хэрэглэгч буюу захиалагч байгууллагаас тайлбар, тодруулга гаргуулах, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. *(Асуудлын шинжилгээг хавсралт 2, аудитын арга зүйг хавсралт 3-аас үзнэ үү)*

Архангай, Баянхонгор, Бүлган, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд аймгууд, нийслэл дэх Төрийн аудитын газрууд УАГ-аас хүргүүлэх маягтын дагуу судалгаа хийж, дүнг 2018 оны 3 дугаар сарын 12-ны дотор аудитын багт ирүүлнэ.

Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар нь нэгдсэн маягтын дагуу судалгаа хийхдээ холбогдох мэдээллийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьсан НХОГ, аймгийн ГХБХБГ-аар гаргуулж, хянан, нотлох баримтыг хавсаргасан байна. Нотлох баримтад дуусаагүй орхигдсон барилгын чанар байдал, цаашид ашиглалтын шаардлага хангах эсэх талаар аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан дүгнэлтийг хавсаргана.

Аудитад дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжтой эсэх талаар лабораторийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах мэргэжлийн байгууллагыг гэрээгээр ажиллуулна.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Иргэний хууль,
- Барилгын тухай хууль,
- Барилгын норм ба дүрэм,
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрхийн акт

10. Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл

Аудитын урьдчилсан судалгааны ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлүүлсэн бөгөөд 2018 оны 02 дугаар сарын 06-ны дотор аудитын төлөвлөгөөг батлуулж, талбарын ажлыг 2018 оны 02 дугаар сарын 12-ноос 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд гүйцэтгэнэ. Тайлагналын үе шат, чанарын хяналтыг 2018 оны 03 дугаар сарын 27-ноос эхлэн хэрэгжүүлнэ.

Аймаг, нийслэл дэх төрийн аудитын байгууллагууд аудитын газруудаар дамжуулан аймаг, нийслэлийн Засаг дарга, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн эрх бүхий байгууллагуудын гаргасан тайлбар, асуулга, төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг 2018 оны 03 дугаар сарын 20-ны дотор нэгтгэлд хүлээн авч, аудитын нэгдсэн тайланг бэлтгэж, 05 дугаар сарын 01-ний дотор УИХ-д хүргүүлнэ. *(Аудитын хөтөлбөрийг хавсралт 4-өөс үзнэ үү.)*

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна холбогдох байгууллагын саналыг тусгана.

11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг нэгдсэн удирдамжаар хийх бөгөөд УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор М.Давааням хянан удирдаж, аудитын менежер Л.Эрдэнэчулуун үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, хөтөлбөрийн дагуу ахлах аудитор Б.Саруул, аудитор Ц.Цолмон, Б.Лхагвацэрэн, Б.Хаш-Эрдэнэ нар гүйцэтгэнэ.

Аудитын явцад аудитын багтай хамтран ажиллах мэргэжлийн байгууллага, гэрээт ажилтнуудыг татан оролцуулна.

12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

а. Боловсон хүчин: УАГ: 4 хүн*60 хүн/өдөр =240 хүн/өдөр

б. Санхүүгийн нөөц:	Цалин	–	6.8 сая төгрөг
	Гэрээт ажилтны зардал	–	3.2 сая төгрөг
	Лабораторийн шинжилгээний зардал	–	172.0 сая төгрөг,
	Дотоод томилолтын зардал	–	7.3 сая төгрөг
	Нийт	–	189.3 сая төгрөг

в.Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг хянаж, зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



С.ОЮУНБИЛЭГ

Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 М.ДАВААНЯМ

АУДИТЫН МЕНЕЖЕР

 Л.ЭРДЭНЭЧУЛУУН

АХЛАХ АУДИТОР

 Б.САРУУЛ

АУДИТОР

 Б.ХАШ-ЭРДЭНЭ

 Б.ЛХАГВАЦЭРЭН

2018 оны 2 дугаар сарын 06-ны өдөр

--o0o--

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудад хийх аудит

А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн дуусаагүй барилга, байгууламжийн орхигдсон үндэслэл, шалтгааныг тгтгөөсөн уу?

А.1. Төсөл, арга хэмжээний төлөвлөлт хуулийн шаардлагад нийцсэн үү?

А.2. Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг барилга угсралтын ажлын явцад үр нөлөөтэй хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг хугацаанд нь бодигтой үнэлж, баталгаажуулсан уу?

А.3. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгаж, хэрэгжүүлсэн үү?

А.4. Гүйцэтгэгч байгууллага барилга угсралтын ажлыг багтагдсан зураг төсөл, барилгын норм дүрмийн дагуу гүйцэтгэсэн үү?

А.5. Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг орхигдсон төсөл, арга хэмжээ бүрт оновчтой төлөвлөж, хуваарилж олгосон уу?

А.6. Гүйцэтгэгч байгууллага төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан уу?

Б.1. Барилга, байгууламжийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдол хэвээр байна уу?

Б.2. Дутуу орхигдсон барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх замаар цаашид ашиглах боломжтой юу?

Б.3. Барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагагүй барилга, байгууламжийн учруулсан хохирлыг бодитой тогтоож, хариуцлага тооцсон уу?

